

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээс чөлөөлөх тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, 8.11.26 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны гишүүдийн 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

- Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хараат бус гишүүн Загдхүүгийн Нарантуяа нь гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт ирүүлсэн тул 2024 оны 11 дүгээр сарын 4-ний өдрөөр дуусгавар болгон түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
- Холбогдох хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлох этгээдийг сонгон шалгаруулж, ТУЗ-ийн хуралд танилцуулах, томилуулахыг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо (Ж.Болормаа)-нд даалгасугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА